



<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Итгэл, М., Отгонбаатар, Х., Санжаабадам, С., Туяа, У., Энхжаргал, Х., & Дэнсмаа, Ж. (2024). Монголын боловсролын тогтвортой хөгжүүлэх үзэл санаа. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл*, 29(2). https://doi.org/10.56380/mjer.v29.2_1

Монгол улсын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санаа

Миесжавын Итгэл 

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

Хажидмаагийн Отгонбаатар 

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

Сэдийн Санжаабадам 

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

Ухнаагийн Туяа 

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

Халтарын Энхжаргал 

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

Жаргалсайханы Дэнсмаа 

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

Concepts to Develop Education in Mongolia from a Sustainable Perspective

Miyejav Itgel 

Mongolian National Institute for Educational Research

Khajidmaa Otgonbaatar 

Mongolian National Institute for Educational Research

Sanjaabadam Sed 

Mongolian National Institute for Educational Research

Tuya Ukhnaa 

Mongolian National Institute for Educational Research

Enkhjargal Khaltar 

Mongolian National Institute for Educational Research

Densmaa Jargalsaikhan 

Mongolian National Institute for Educational Research

To cite this article:

Miyejav, I., Otgonbaatar, Kh., Sed, S., Ukhnaa, T., Khaltar, E., & Jargalsaikhan, D. (2024). Concepts to develop education in Mongolia from a sustainable perspective. *Mongolian Journal of Educational Research*, 29(2). https://doi.org/10.56380/mjer.v29.2_1

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Монгол улсын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санаа

Миеэжавын Итгэл, Хажидмаагийн Отгонбаатар, Сэдийн Санжаабадам, Ухнаагийн Туяа, Халтарын Энхжаргал, Жаргалсайханы Дэнсмаа

Өгүүллийн мэдээлэл

Өгүүллийн түүх:

Хүлээн авсан: 2024.06.24
Засаж сайжруулсан: 2024.07.22
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2024.08.22

Түлхүүр үг:

VUCA
Тогтвортой хөгжил
Монголын боловсрол
Боловсролын үзэл санаа
Үндэсний соёл, уламжлал

ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд Монголын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санааг нийгмийн олон салбарын 1464 төлөөллийг танхим, цахимаар хамруулан хэлэлцүүлж, оролцогчдоос ирүүлсэн санал, зөвлөмжөөс гарсан үр дүнг экспертний ярилцлагаар сайжруулан үндэсний чуулганаар хэлэлцүүлж баталгаажуулсан үр дүнг танилцуулав. Монголын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санааны нэгэн хувилбарыг боловсролын динамик загварт суурилан: Оршин тогтнохын үндэс нь *Монголын боловсролын философи*, Чиглэх алтан гадас нь *Алсын хараа*, Алсын хараа руу хөтлөх луужин нь *Үнэт зүйл*, Нийгэмд төлөвших хүн нь *Монгол суралцагч*, Монгол суралцагчийг дэмжих *Тэргүүлэх чиглэлүүд*, Олон нийтийн оролцоог эрхэмлэсэн *Хамтын ажиллагаа*, *түншлэл*, Хэрэгжилтийг найдвартай, тогтвортой байлгах *Боловсролын цахим шилжилт ба их өгөгдөл*, Үр дүнд суурилсан *Боловсролын санжүүжилт* гэсэн бүтцийн хүрээтэй байхаар тодорхойлов.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Миеэжавын Итгэл
Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн
Email: itgel@mier.mn

Concepts to Develop Education in Mongolia from a Sustainable Perspective

Itgel Miyejav, Khajidmaa Otgonbaatar, Sanjaabadam Sed, Tuya Ukhnaa, Enkhjargal Khaltar, Densmaa Jargalsaikhan

Article information

Article history:

Received: Jun 24, 2024
Revised: Jul 22, 2024
Accepted: Aug 22, 2024

Keywords:

VUCA
Sustainable education
Mongolian education
Educational concepts
National culture and tradition

ABSTRACT

This article introduces a concept to develop education in Mongolia from a sustainable perspective by employing a dynamic model of education. The concept to develop education in Mongolia from a sustainable perspective emphasizes 8 components, including Education philosophy of Mongolia (as the foundation of existence), Vision (as a pole star), Values (as a compass leads to the pole star), Mongolian learner (as a future social member), Policy priorities (as assistance to Mongolian learner), Collaboration and Partnership (as public engagement), Digital transformation and Big Data (as reliable and sustainable implementation mechanism), and Education finance (as an efficiency-directed mechanism).



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Miyejav Itgel
Mongolian National Institute for Educational Research
Email: itgel@mier.mn

УДИРТГАЛ

Монгол улсын тулгар төр анх үүссэн цаг буюу НТӨ 209 онд Хүннүчүүд тамга (Эрдэнэбаатар ба бусад, 2002) хэрэглэж байжээ. Монголчууд нь монгол (X-XII зуун), дөрвөлжин (1269 он), тод (1648 он), соёмбо (1686 он) үсэг, бичиг (Надмид, 1967; Шагдарсүрэн, 1981) үүсгэн хэрэглэж байсан түүхэн баримтууд байна. Мэдээллийг нэгэн утгатай ойлгох тэмдэгтийг боловсролтой холбон тайлбарлавал манай улсын боловсролын нэгэн шинэ түүх гарч ирэх юм. Бид боловсролыг бичиг үсэгт тайлагдаагүй үед буюу уншиж, бичихийг бүтээхээс өмнө, өвөг дээдэс маань өв соёлоо нэг үеэс нөгөөд аман хэлбэрээр дамжуулж ирсэн үеэс эхэлнэ (Ornshtein, Levine, 2008, p. 55) хэмээвэл монголчуудын боловсролын түүхийн цаг хугацаа нэн урагшлах билээ. Энэ үүднээс авч үзвэл Монголын боловсролын түүх тулгар төр байгуулагдснаас өмнө үүссэн гэж үзэх үндэстэй.

Сүүлийн 200 жилийн хугацаанд боловсролын тогтолцоо нь улам боловсронгуй болж, эдийн засгийн хөгжил, нийгэм, төрийн болон олон нийт, хамт олны ахин дэвжих гол хөдөлгүүр нь болж байгаатай холбоотой. Боловсрол нь нийгэмд хийгээд хувь хүнд хэрэгцээтэй мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйл бүрэлдэх үндэс болж, боловсролоор дамжуулан нийгмийн эв нэгдлийг хадгалж, хүмүүсийг идэвхтэй иргэн болгон төлөвшүүлж, амьдрах чадвартай болгосноор бидний өнөөгийн амьдарч буй нийгмийг үндсээр нь бүрдүүлж өгсөн (OECD, 2021) ажээ.

XX зууны Монгол улсын боловсролын талаар, Академич Н.Бэгз (2017, х. 145 - 156) дараах дүгнэлтийг өгсөн байна. 1910-аад оноос орчин цагийн гэх боловсролын тогтолцоог хөгжүүлэхдээ тэр үеийн Орос, хожим нь Зөвлөлтийн боловсролын тогтолцоог бүхэлд нь дуурайлган тогтоосон юм. Улмаар дараа дараагийн жилүүдэд боловсролын тогтолцоог хөгжүүлэхдээ социалист системийн орнуудын боловсролын хөгжлийн хандлагыг дагажээ. Энэ нь нэг талаас өөрийн орны иргэдийн амьдралын хэвшил, соёлын онцлог, монгол хүний сэтгэлгээний өвөрмөц шинжийг тооцолгүйгээр гаднын боловсролын туршлагыг шууд хуулбарлан хэрэглэсэн тал байгаа боловч нөгөө талаас нийгмийн оюуны хөгжлийн түвшин нь дундад зууны үеийнхээ байдлыг хадгалсан Монгол оронд гаднаас шууд экспортлон оруулахаас өөр үр ашигтай, дөт зам тэр үед байгаагүй гэжээ.

Монгол улс нь 1990-ээд оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, социалист системээс чөлөөт зах зээлийн эдийн засагтай, ардчилсан нийгмийн системд шилжин орсон билээ. Үүнтэй уялдуулан боловсролын өөрчлөлт шинэчлэлийг эрин үеийн нийгэм-түүхийн бодит нөхцөл, хэрэгцээ, шаардлагад үндэслэн боловсролын бүх төвшин, бүрэлдэхүүн хэсгийг хамарсан, цогц шинжтэй, бүхэл бүтэн тогтолцооны шинэчлэл хийх хэрэгтэй болов (БСШУСЯ, БХ & ЮНЕСКО, 2019, х. 77). Улмаар нийгэмд боловсролын тогтолцоог зохицуулах БНМАУ-ын боловсролын үзэл баримтлал (1991), Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (1995, 2015), Монголын боловсролын мастер төлөвлөгөө (1993, 2006), Боловсролын багц хуулиуд (2002, 2008, 2009, 2023) батлагджээ.

Мөн XXI зуунд “Тогтвортой хөгжил” гэх шинэ нэр томъёо гарч ирснээр урьд өмнө бидний хөгжлийн бүх загвар амьдрах чадваргүй болох нь тун тодорхой болов. (ЮНЕСКО & ШУА, 2016). Үүнтэй уялдуулан Монгол улсад Бага, дунд боловсролын киррикулим, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал (2002), Боловсролын стандартууд (2003 - 2004) зэрэг эрх зүйн баримт бичиг тухайн цаг үед шинэчлэх шийдлүүдийг хийсэн байна. Мөн Доёд, Нэргүй, Шагдар (1993), Мөнхдалай (1998), Бүжидмаа (2001), Пүрэвдорж (2002), Бэгз & Бадарч (2005), Бэгз (2008), Энхтүвшин (2014, х. 28 – 39) зэрэг эрдэмтэн судлаачдын Монголын боловсролыг цогцоор хөгжүүлэх зорилго бүхий боловсролын системийн хандлагын судалгааны бүтээлүүд гарсан байна.

2015 онд НҮБ-ын Ерөнхий асамблейн 70-р чуулганаар “2030 хүртлэх тогтвортой хөгжлийн хөтөлбөр” батлав. Энэ нь Засгийн газар хоорондын амлалт бөгөөд “хүмүүс, гараг дэлхий, хөгжил цэцэглэлтийн төлөөх үйл ажиллагааны төлөвлөгөө” юм. Энэ нь тогтвортой хөгжлийг эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээнд хоорондоо салшгүй цогц, харилцан уялдаа, тэнцвэр бүхий Тогтвортой хөгжлийн 17 зорилгоос бүрдэнэ. Энд боловсролын асуудлыг Зорилго 4. Чанартай боловсрол гэсэн бие даасан зорилго, 7 зорилт, хэрэгжүүлэх 3 арга замын хамт тодорхойлжээ (ЮНЕСКО, 2016).

“Монгол улсын боловсролыг 2006–2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг үнэлэх, цаашдын мастер төлөвлөгөөг боловсруулах зорилгоор “Монгол улсын боловсролын суурь

мэдээллийн тайлан” боловсруулжээ (БСШУСЯ, БХ & ЮНЕСКО, 2019). Тайланд боловсролын тогтолцоо, дэд секторууд; боловсролын дэд сектор дамнасан асуудлууд гэсэн хоёр бүлэгтэй ба нийт 13 дэд бүлгээр ололт, амжилт, тулгарч буй асуудал, зөвлөмж саналыг бичжээ. Тус тайлан нь Монголын боловсролыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах бүтээл гэж бид үзэж байна.

Монгол Улсын Их Хурал 2020 оны 5 сарын 13-д “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого баталлаа. Энд зорилт 2.1. нь боловсрол бөгөөд “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэжээ (УИХ, 2020). Үүнтэй уялдуулан, 2020 оны 10 сарын 09-нд Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-г батлав. Тус төлөвлөгөө нь “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор нь хөгжүүлэх” зорилгыг дэвшүүлж, нийт 15 зорилт, 47 хөтөлбөр, 254 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ (БШУЯ, 2020).

Өнөөдрийн нийгмийн хөгжил эрчимжиж, улам нарийн төвөгтэй нөхцөл байдал үүсэж буйг VUCA (volatility, uncertainty, complexity, ambiguity) буюу тогтворгүй, тодорхойгүй, ээдрээтэй, олон санаа агуулсан байдал гэж үзэж уг нөхцөлд ирээдүйгээ төсөөлөх, таамаглах нь ирээдүй үргэлж өөрчлөгдөж байдаг бидний үйлдлийн үр дагавар гэсэн үзлээр хандахад хүргэж байна (OECD, 2021). Тухайлбал:

-2018 онд Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас “Суралцахуйн хүрээ 2030”-ийг тодорхойлж хариуцлага хүлээх, шинэ үнэт зүйлийг бүтээх, хурцадмал байдал болон бэрхшээлийг зохицуулах чадвартай суралцагч бэлтгэх хэрэгтэй гэж үзсэн байна (OECD, 2019).

-2020 онд Дэлхийн эдийн засгийн форум (WEF)-ын шинэ нийгэм, эдийн засгийн ирээдүйн дүр төрхийг тодорхойлох зөвлөлдөх хэлэлцүүлэг хийж аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үеийн чанартай боловсролын загварыг тодорхойлсон бөгөөд энэ санаачилгыг “Боловсрол 4.0” гэж нэрлэсэн. Улмаар 2023 онд Боловсрол 4.0 таксономи боловсруулжээ (WEF, 2023).

-2021 онд ЮНЕСКО (UNESCO) боловсролын хөгжлийн цоо шинэ үе эхэлж байна гэж үзэж, Боловсрол 2050 он хүртэл хэрхэн өөрчлөгдөх талаар судалгааны тайланд боловсролд бид юуг хадгалж үлдэх, юуг цааш үргэлжлүүлэх, юуг орхих, юуг өөрчлөх, юуг шинээр бүтээж цааш хөгжүүлэх гэсэн асуултад хариулахыг эрмэлзсэн байна (UNESCO, 2021).

2022 оны 1-р сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутариш тухайн жилийн Ерөнхий Ассамблейг “Transforming Education” нэртэй зохион байгуулахаар төлөвлөж буйгаа мэдэгдэн Ирээдүйн боловсролыг дахин төлөвлөх, ТХЗ 4-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сурлагын хоцрогдлыг арилгах бодлого чиглэл, арга замыг талуудын оролцоотой тодорхойлох зорилготой улс орон бүр өөрийн орны боловсролын талаар хэлэлцүүлэг зохион байгуулахыг уриалсан юм. 2022 оны 6–7 сард Монгол улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (БШУЯ), Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ) хамтран “Хувьсаж буй боловсрол” үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулж, олон нийтийн 8 салбарын төлөөллийн нийт 4000 гаруй оролцогч хамрагдлаа. Энэхүү хэлэлцүүлгээр 5 хүрээнд нийт 960 санал, санаачилга гарсан бөгөөд багцлан 20 болгосон юм (БШУЯ, БСҮХ, 2022).

Хүснэгт 1. “Хувьсаж буй боловсрол” үндэсний хэлэлцүүлгийн үр дүн

Агуулгын хүрээ	Санал, санаачилга	Багцалсан санал
Дижитал суралцахуй ба хувьсаж буй боловсрол	214	5
Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургууль	223	5
Амьдрал, ажил хөдөлмөр, тх-ийн төлөөх суралцахуй ба ур чадвар	158	3
Багш мэргэжил	208	4
Боловсролын санхүүжилт	157	3

Улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 77 дахь дээд хэмжээний уулзалт нь “Transforming Education” нэртэй болж үндэсний хэлэлцүүлгээс гарсан үр дүнг Монгол улсын БШУ-ы сайд Л. Энх-Амгалан чуулганы индэрт хэлэлцүүлсэн юм (Enkh-Amgalan, 2022).

Монголын боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Боловсролын багц хуулийг хоёр жил гаруй хэлэлцэн 2023 оны 07 сарын 07-нд баталлаа (УИХ, 2023). Энэ нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль болно. Өөрөөр хэлбэл, өнөөдөр Монгол улсын боловсрол нь хөгжлийн зорилго, тогтвортой хөгжлийн үзэл, эрх зүйн орчин шинэ нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бүрэлдэн тогтсон байна.

Энэ бүхний үр дүнд өнөөдөр Монгол улсын боловсролын хөгжлийн зорилго, тогтвортой хөгжлийн үзэл санаа, эрх зүйн орчин нь шинэ нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бүрэлдэн тогтсон байна. Гэхдээ бид боловсролын зорилгодоо хүрэх арга хэрэгсэл, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үнэлгээ, мониторинг зэрэг нь бүхэлдээ тодорхойгүй төлөвт байна гэж үзэв. Боловсролын системийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бүхэлд нь бус бие биеэс нь салангид авч үзвэл суралцагчийн, хүний нөөцийн, орчны зэрэг онцлогийг бүрэн тусгаж чадахгүй болдог (Итгэл ба бусад, 2023). Монголын боловсролд боловсролыг системээр нь авч үзэх хандлага сул байгаа нь бидний судалгааны асуудал болно.

Иймд Монголын боловсрол нь VUCA-г хэрхэн даван туулах вэ? (Aris, Omar & Hashim, 2021, p. 2-6) гэсэн асуултад хариулах замаар асуудлыг шийдэх нь нэг шийдэл гэж үзлээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Монголын боловсролыг хувирган өөрчлөх шийдэл

VUCA гэж юу вэ?	VUCA-г хэрхэн даван туулах вэ?	Монголын боловсролын хувирган өөрчлөлтийн шийдэл
Volatility (Тогтворгүй)	Vision (Алсын хараатай байх)	Алсын хараа (Алтан гадсаа олох)
Uncertainty (Тодорхойгүй)	Understanding (Нэгдсэн ойлголттой болох)	Үнэт зүйл (Алсын хараа руу чиглэхэд баримтлах зарчим)
Complexity (Ээдрээтэй)	Clarify (Тодорхой байх)	Суралцагчийн дүр төрх (Ямар хүн байх вэ?)
Ambiguity (Олон утгатай)	Agility (Хариу үйлдэл үзүүлэх)	Тэргүүлэх чиглэл (Хэрэгжилтийн чиглэлүүд)

АРГА ЗҮЙ

Агуулгын илрүүлэх аргачлал

Монголын боловсролын хувирган өөрчлөлтийн шийдлийг боловсрол ба экосистем, бүтцийн, динамик гэсэн гурван загварт (Итгэл ба бусад, 2023) тулгуурлана. Үүнд:

- Боловсрол ба экосистемийн загвараас
 - Монголын боловсролын экосистемийн ангиллыг тодорхойлох
 - Экосистемийн ангилал бүрд алсын харааг тогтоох,

- Алсын хараа бүрд чиглэсэн үнэт зүйлийг илрүүлэх,
 - Үнэт зүйл дээр суурилан суралцагчийн дүр төрхийг гаргах
2. Боловсролын бүтцийн загвараас:
- Монголын боловсролын бүтэц буюу бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох
 - Тус бүтэц нь суралцагч төвтэй байх
 - Тус загвараас тэргүүлэх чиглэлийг тогтоох
3. Боловсролын динамик загвараас
- Бүтцийн загварын бүрэлдэхүүн бүрийг хугацааны хувьд эрэмбэлэн байрлуулах
 - Динамик загвараас зарим бүрэлдэхүүн хэсгийн агуулгыг илрүүлэх
- гэсэн шийдлийг гаргана.

Үйл явц ба оролцогчид

Монголын боловсролын экосистемийг үндэсний соёл, уламжлал (national culture & tradition), хувь хүний (personal), харилцааны (society), нийгмийн (societal), хүн төрөлхтний (human) гэсэн нэг нэгэндээ багтсан 5 бүрэлдэхүүнтэй экосистем байна гэсэн загварт тулгуурлан Монгол Улсын Үндсэн хууль (УИХ, 1992), “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ, 2020), Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан (БСШУСЯ, БХ & ЮНЕСКО. 2019) зэрэг эрх зүйн, хөгжлийн бодлогын баримт бичиг болон Монголын боловсролын бодлогын судалгааг үндэслэн эхний хувилбарыг тодорхойлсон. Харин Монголын боловсролын бүтцийн болон динамик загварыг (Итгэл ба бусад, 2023) санал болгосон.

Улмаар тус хувилбарыг хэлэлцүүлэг, ярилцлага (БСҮХ-ийн эрдмийн зөвлөл, үндэсний чуулган), уулзалт-мэтгэлцээн, Янусын конус зэрэг аргаар цуглуулсан мэдээллийг үндэслэн сайжрууллаа.

Хэлэлцүүлэг. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн судлаачид, 9 салбарын төлөөллийн нийт 1464 оролцогчид хэлэлцүүлэг хийв (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Боловсролын болон олон нийтийн төлөөллийн хэлэлцүүлэг

Оролцогч	Танхимаар оролцогч	Цахимаар оролцогч
Салбар салбарын төлөөлөл	1254	210
ИДС-ийн багш, төсөл хөтөлбөрийн зөвлөхүүд		
Хувийн хэвшлийн СӨБ болон ЕБС-ийн төлөөлөл		
ЗГХЭГ-ын төлөөлөл		
Хүүхэд залуучуудын төлөөлөл		
ШУА-ийн харьяа хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид		
СӨБ болон ЕБС-ийн багш нар		
Аймаг, нийслэлийн БШУГ-ын мэргэжилтнүүд		
Мэргэжлийн байгууллагын төлөөлөл		

Ярилцлага. Хэлэлцүүлгийн дараа гарсан үр дүн дээр суурилан боловсролын шинжлэх ухааны 3, боловсролын 21 доктор нэг бүртэй 30–120 минутын хугацаанд ганцаарчилсан ярилцлага хийв. Эдгээр оролцогчид судалгааны экспертүүд болно.

Янусын конус. Монголын боловсролын үнэт зүйлийн ангилал болох “үндэсний соёл, уламжлал” ангиллын хувьд ойлгомжтой мэт боловч, яг юуг нь үнэт зүйл болгох вэ? гэдэгт хэлэлцүүлэгт оролцогчид нэгдсэн ойлголтод хүрч чадахгүй, гаргаж буй шийдэл нь оновчтой бус гэж экспертүүд үзсэн юм. Мөн экспертүүд шинээр аргачлал боловсруулан хандахыг зөвлөсөн болно.

Цаг хугацааны хувьд өнгөрсөн ба ирээдүйг харж, түүхэн зүйлсийг тодорхойлж, ирээдүйд болох зүйлд цаг хугацаа хэрхэн нөлөөлөхөд Янусын конус (Janus cones) аргыг ашигладаг байна (Carleton, Coskayne & Tahvanainen, 2013, p. 81). Түүхэн зүйлсийн талаар онцгой бодол санаагаар түүхэнд

тэмдэглэгдэн үлддэг. Энэ арга нь олон үйл явдлын талаар олон хүний санаа бодлыг тусгах замаар бүрэн ойлгоход тусалдаг. Хоёр конусын зүүн талынх нь өнгөрсөн, баруун талынх нь ирээдүй, уулзвар нь одоо цагийг тус тус дүрсэлнэ. Өнгөрснийг эргэн санахад хүний ой ухаан бүрэн зураглаж чадахгүй байх талтай. Мөн ирээдүйд юу болох нь ч бас бидэнд тодорхой бус байдаг. Тиймээс энэ аргыг “тодорхойгүйн конус (cone of uncertainty)” ч гэдэг.

Түүхэн цаг хугацаанд Монголчуудын үндэсний соёл, уламжлалд “нийгэм”, “соёл” гэсэн хоёр хүчин зүйл хамгийн их нөлөөлсөн гэж үзсэн. Түүхэн агуулгын хувьд “Монгол угсаатны сурган хүмүүжүүлэх ухаан” судалгааны 164 эх сурвалжид тулгуурлан хайлт хийв. Ирээдүйн хувьд Дэлхийн эдийн засгийн форум (WEF, 2020) ирээдүйн топ 10 ур чадвар (future skill)-ыг тодорхойлж, улмаар дөрвөн төрөлд ангилсан байна. Үүнийг ирээдүйн конусын үйл явдлаар тодорхойлов.

БСҮХ-ийн эрдмийн зөвлөл (2023.09.04). Эрдмийн зөвлөлийн хурлаар БСҮХ-ийн захирал М. Итгэлийн “Монголын боловсролыг хөгжүүлэх онолын үндэслэл” мэдээллийг хэлэлцэв. Монголын боловсролын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрхийн судалгааны арга зүй, үр дүнг дэмжив.

Уулзалт-мэтгэлцээн. Ерөнхийлөгчийн болон ерөнхий сайдын зөвлөхүүд, УИХ-ын боловсрол хариуцсан төлөөлөл, Боловсрол, шинжлэх ухааны яамны баг бүрэлдэхүүнд нийт 12 удаа уулзалт, хурал, дугуй ширээний ярилцлага хийв.

Үндэсний чуулган (2024.03.04-05). БШУЯ болон БСҮХ нь “Монголын боловсролын хувирган өөрчлөлт” үндэсний чуулганыг зохион байгуулав. Тус чуулганд 21 аймаг, 9 дүүргийн төрийн байгууллагын төлөөлөл 16, Сурагчдын төлөөлөл 34, Залуучуудын төлөөлөл 89, Сургалтын байгууллагын төлөөлөл 206, Аймаг, нийслэлийн БШУГ-ын төлөөлөл 90, Мэргэжлийн байгууллагын төлөөлөл 86, Эцэг эхийн төлөөлөл 22, Малчин иргэдийн төлөөлөл 8, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 25, Нам, эвслийн төлөөлөл 10, Бизнес эрхлэгчдийн төлөөлөл 14 буюу нийт 600 хүн оролцжээ.

ҮР ДҮН

Монголын боловсролын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон үр дүнг зургаар дүрслэн үзүүлье. Эдгээр нь “Монголын боловсролын хувирган өөрчлөлт” үндэсний чуулганд БСҮХ-ийн захирал М. Итгэлийн “Монголын боловсролын хөгжил” мэдээллийн танилцуулгын зургууд болно.


Үр дүн 1. Монголын боловсролын алсын хараа

“Боловсрол ба Экосистем” загварт суурилан Монголын боловсролын алсын харааг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Хүн төрөлхтний нийтлэг соёлыг хүндэтгэх,
- Ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох,
- Гэр бүлийн амьдралын баталгаа болох,
- Хувь хүний хөгжлийг дэмжих,
- Монгол хүнийг төлөвшүүлэх

болно.


Зураг 4. Монголын боловсролын экосистемийн ангилал ба харгалзах алсын хараа



Үр дүн 2. Монголын боловсролын үнэт зүйл

Үнэт зүйл нь Алсын хараа руу хөтлөх луужин нь юм. Иймд “Боловсрол ба Экосистем” загварын 5 ангилал бүрд харгалзах алсын хараа руу чиглэсэн үнэт зүйл нь дэлхийн соёл, хүн чанар, гэр бүл, суралцахуй, Монгол сэтгэлгээ байна.

Зураг 4. Монголын боловсролын экосистемийн ангилал ба харгалзах үнэт зүйл




Үр дүн 3. Монгол суралцагчийн дүр төрх

Ирээдүйн Монгол суралцагчийн шинж буюу дүр төрхийг алсын хараа болон үнэт зүйл дээрээ суурилан тодорхойлсон юм. Иймд Монгол суралцагчийн дүр төрх нь:

- Хүн төрөлхтний соёлыг хүндэтгэдэг, дэлхийн соёлоос суралцдаг “Дэлхийн хүн” ,
- Ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулдаг “Хүнлэг иргэн”,
- Нийгмийн болон гэр бүлийн ”Хариуцлагатай гишүүн”,
- Бие дааж, насан туршдаа суралцдаг ”Тасралтгүй суралцагч”,
- Үндэсний соёл, уламжлал, ёс заншлаа өвлөн хөгжүүлдэг “Соёлыг уламжлагч”


байна.

Зураг 6. Монголын боловсролын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрхийн холбоо



Монгол суралцагчийн дүр төрх нь чадамжаар тодорхойлогдох бөгөөд чадамжийг боловсролын түвшин (СӨБ, ЕБ, МБ, ДБ, НТБ) бүрд залгамж холбоотойгоор хөгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байгаа юм. Түүний дүрслэлийг Зураг 7-д үзүүлэв.

Зураг 7. Монгол суралцагч ба боловсролын түвшингийн холбоо




Дүр төрх	Сургуулийн өмнөх боловсрол	Ерөнхий боловсрол	Мэргэжлийн боловсрол	Дээд боловсрол	Насан туршийн боловсрол
Дэлхийн хүн	Сургуулийн өмнөх боловсролын дэлхийн хүний чадамж	Ерөнхий боловсролын дэлхийн хүний чадамж	Мэргэжлийн боловсролын дэлхийн хүний чадамж	Дээд боловсролын дэлхийн хүний чадамж	Насан туршийн дэлхийн хүний чадамж
Хүнлэг иргэн	Сургуулийн өмнөх боловсролын хүнлэг иргэний чадамж	Ерөнхий боловсролын хүнлэг иргэний чадамж	Мэргэжлийн боловсролын хүнлэг иргэний чадамж	Дээд боловсролын хүнлэг иргэний чадамж	Насан туршийн хүнлэг иргэний чадамж
Хариуцлагатай гишүүн	Сургуулийн өмнөх боловсролын хариуцлагатай гишүүний чадамж	Ерөнхий боловсролын хариуцлагатай гишүүний чадамж	Мэргэжлийн боловсролын хариуцлагатай гишүүний чадамж	Дээд боловсролын хариуцлагатай гишүүний чадамж	Насан туршийн хариуцлагатай гишүүний чадамж
Тасралтгүй суралцагч	Сургуулийн өмнөх боловсролын тасралтгүй суралцагчийн чадамж	Ерөнхий боловсролын тасралтгүй суралцагчийн чадамж	Мэргэжлийн боловсролын тасралтгүй суралцагчийн чадамж	Дээд боловсролын тасралтгүй суралцагчийн чадамж	Насан туршийн тасралтгүй суралцагчийн чадамж
Соёлыг уламжлагч	Сургуулийн өмнөх боловсролын соёлыг уламжлагчийн чадамж	Ерөнхий боловсролын соёлыг уламжлагчийн чадамж	Мэргэжлийн боловсролын соёлыг уламжлагчийн чадамж	Дээд боловсролын соёлыг уламжлагчийн чадамж	Насан туршийн соёлыг уламжлагчийн чадамж

Үр дүн 4. Монголын боловсролын тэргүүлэх чиглэл

Монголын боловсролын бүтцийн болон динамик загварыг (Итгэл ба бусад, 2023) санал болгосон бөгөөд энэ нь 7 хэсгээс тогтох загвар билээ. Эндээс бид Зорилго, суралцагч гэсэн бүрэлдэхүүн хэсгийг дээр тодорхойлсон тул үлдсэн 5 хэсгийг тэргүүлэх чиглэл гэж үзлээ. Үүнд: сургалтын хөтөлбөр, хүний нөөц, боловсролын орчин, удирдлага-менежмент, үнэлгээ-мониторинг зэрэг багтана.

Зураг 8. Монголын боловсролын бүтцийн болон динамик загвар



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Бид гарсан үр дүнд тулгуурлан судалгааг зохион байгуулах үйл явцад Монголын боловсролыг илүү учир утгатай хөгжүүлэх шийдлийг санал болгож байна.

Бид юуг хүлээн зөвшөөрч, юуг хөгжүүлэх вэ?

Дэлхий дахинаа

- нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал,
- хүн амын өсөлт, эрчимтэй хотжилтын асуудал,
- уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн хомсдол,
- шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил,
- хиймэл оюун ухаан, их өгөгдлөөс үүдэн

ирээдүйн төлөв байдал тодорхойгүй, таамаглахад бэрхтэй, тогтворгүй, ээдрээтэй байгааг хүлээн зөвшөөрч,

Хүн төрөлхтний сайн сайхны төлөө эрмэлзлийг хүлээн зөвшөөрөх нь бүх нийтийн үйл хэрэг болохыг үндэс болгон,

Эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг Монголын ард түмний туйлын эрмэлзэл хэмээн үзэж,

Төрт ёс, өв соёлоо дээдэлж, хүмүүсийн эв эетэй харилцааг хөгжүүлэхэд нэн чухал болохыг онцгойлж,

Хувь хүний утга учиртай амьдралыг хөхиүлэн дэмжиж,

Үндэсний түүх, соёл, уламжлал, хэл, бичиг, сэтгэлгээ болон язгуур шинж, онцлогоо ухамсарлан, Монголын боловсролыг даяарчлалын хандлагатай, үндэсний онцлогтойгоор хөгжүүлэхээр зорино.

Үүний тулд Бид юунд зорих вэ?

Хүн бүрийн сурч боловсрох эрхийг хүндэтгэн,

Тэдэнд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж,

Боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэхийг зорин,

Монголын боловсролыг хөгжүүлэхэд шаардлагатай

- Оршин тогтнохын үндэс нь Философи,
- Чиглэх алтан гадас нь Алсын хараа,
- Алсын хараа руу хөтлөх луужин нь Үнэт зүйл,
- Нийгэмд төлөвших хүн нь Монгол суралцагч,
- Монгол суралцагчийг дэмжих Тэргүүлэх чиглэлүүд,

- Олон нийтийн оролцоог эрхэмлэн Хамтын ажиллагаа, түншлэл,
- Хэрэгжилтийг найдвартай, тогтвортой байлгах Боловсролын цахим шилжилт ба их өгөгдөл
- Үр дүнд суурилсан Боловсролын санхүүжилт гэсэн 8 зүйлийг тодорхойлж байна.

Нэг зүйл. Монголын боловсрол нь философитой байна.

- Монголын боловсролын философийг боловсролын даяарчлал, үндэсний онцлогт тулгуурлан хөгжүүлнэ.
- Монголын боловсролын философи нь Монгол Улсын боловсролын хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах нэг үндэслэл болно.
- Монголын боловсролын философи нь судлаач, эрдэмтэн, багш, иргэн бүрийн үзэл бодлоо илэрхийлэх академик эрх чөлөөний талбар байна.

Нэг зүйл. Монголын боловсролын алсын хараа

- Монголын боловсрол нь хүн бүрд эдийн засаг, улс төр, нийгмийн үйл ажиллагаанд оролцох, шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжлийн дэвшилтэт ололт амжилтаас хүртэх, оролцох, уур амьсгал-эко системийн өөрчлөлт зэрэг сорилтуудыг даван туулахад шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, тэдний аз жаргалтай амьдрах бүхий л боломжуудад дэмжлэг үзүүлдэг байх ёстой. Үүний тулд уламжлалт боловсролын тогтолцооны зорилгоос давсан “Алсын хараа”-г тодорхойлох шаардлагатай.
- Монголын боловсролын алсын харааг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:
 - Хүн төрөлхтний нийтлэг соёлыг хүндэтгэх,
 - Ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох,
 - Гэр бүлийн амьдралын баталгаа болох,
 - Хувь хүний хөгжлийг дэмжих,
 - Монгол хүнийг төлөвшүүлэх

•Мэдээлэл технологийн дэвшилд тулгуурласан хөгжил нь бидний урьд өмнө байгаагүй шинэ боломжуудыг бий болгож байна. Бид түүнийг боловсролынхоо үр ашгийг дээшлүүлэхэд ашиглах болно.

Нэгэн зүйл. Монголын боловсролын үнэт зүйл

- Монголын боловсролын алсын хараа руу тэмүүлэхийн тулд баримтлах зарчимтай байна. Эдгээр зарчмыг үнэт зүйлсээр тодорхойлж байна.
- Үнэт зүйл нь хүн төрөлхтөн, нийгэм, хүн хоорондын харилцаа, хувь хүн, үндэсний соёл, уламжлалд үзүүлэх боловсролын нөлөөлөл бөгөөд энэ нь суралцагч нийгэмд иргэн болон төлөвшихөд чиглүүлэх луужин юм.
- Монголын боловсролын үнэт зүйл нь
 - Дэлхийн соёл,
 - Хүн чанар,
 - Гэр бүл,
 - Суралцахуй,
 - Монгол сэтгэлгээ байна.
- Монгол улс боловсролын үнэт зүйлээ тодорхойлох нь боловсролыг өөрийн онцлогтой хөгжүүлэх үндэсний тэмүүллийн эх үндэс болно.

Нэгэн зүйл. Монгол суралцагчийн дүр төрх

- Монголын боловсролын тогтолцоо нь суралцагч төвтэй байна.
- Монгол суралцагчийн дүр төрх нь:
 - Хүн төрөлхтний соёлыг хүндэтгэдэг, дэлхийн соёлоос суралцдаг “Дэлхийн хүн” ,
 - Үндэсний соёл, уламжлал, ёс заншлаа өвлөн хөгжүүлдэг “Соёлыг уламжлагч”
 - Ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулдаг “Хүнлэг иргэн”,
 - Нийгмийн болон гэр бүлийн ”Хариуцлагатай гишүүн”,
 - Бие дааж, насан туршдаа суралцдаг ”Тасралтгүй суралцагч”байна.
- Монгол суралцагчийн дүр төрх нь чадамжаар тодорхойлогдох бөгөөд чадамжийг боловсролын түвшин бүрд залгамж холбоотойгоор хөгжүүлнэ.

- Хүн бүр Монгол суралцагчийн дүр төрхийг бүтээхийн төлөө өөрийн нөөц бололцоог бүрэн ашиглан суралцана.

Нэгэн зүйл. Монголын боловсролын тэргүүлэх чиглэл

- Хүн бүрд Монгол суралцагчийн дүр төрхийг бүтээхэд дараах бүрдлийг тэргүүлэх чиглэлээр тодорхойлж байна. Үүнд:
 - Сургалтын хөтөлбөр,
 - Хүний нөөц,
 - Боловсролын орчин,
 - Удирдлага, зохион байгуулалт,
 - Үнэлгээ, мониторинг
- Монгол суралцагчийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсролын түвшин бүрээр залгамж холбоотойгоор олон талын оролцоотойгоор боловсруулна.
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, боловсролын орчныг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан бүрдүүлнэ.
- Боловсрол, сургалтын байгууллагын удирдлага, менежментийг нотолгоо, оролцоонд суурилан, ахиц дэвшлээ тооцон системийн үр ашигтай уялдуулан хөгжүүлнэ.
- Бүх түвшний боловсролын зорилго, үр дүнг бодитой, тохирцтой, найдвартайгаар үнэлж, хэмжээсжүүлсэн баталгаатай мэдээллээр оролцогч талуудыг хангах, тэдний амжилтыг ахиулах боломжийг нэмэгдүүлнэ.
- Үндэсний, орон нутгийн, байгууллагын түвшинд хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, үр дүнг ашиглах чадавхыг тасралтгүй бэхжүүлнэ.

Нэгэн зүйл. Хамтын ажиллагаа, түншлэл

Боловсролыг бүх нийтийн сайн сайхан байдалд хөтлөх арга зам болохын хувьд дараах талуудын оролцоо, түншлэлийг эрхэмлэнэ. Үүнд:

- Боловсролын дэд салбарууд,
- Төр, хувийн хэвшлийн байгууллагууд,
- Иргэний нийгмийн байгууллагууд
- Нам, эвсэл,
- Нийгмийн бусад бүлгүүд,
- Гэр бүл

Нэгэн зүйл. Боловсролын цахим шилжилт ба их өгөгдөл

- Монголын боловсролын хувирган өөрчлөлтийг эрчимжүүлэхэд цахим технологийг тууштай ашиглана.
- Цахимаар суралцахуйг дэмжих олон талт үйл ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.
- Боловсролын их өгөгдлийн санг бүрдүүлэхэд найдвартай, тохиромжтой гэсэн хэмжилтийн зарчимд тулгуурласан чанартай өгөгдөл цуглуулна.
- Их өгөгдөлд тулгуурласан суралцахуйн сайн туршлага, үр дүнгийн мэдээлэл нь суралцагчийн цаашдын боловсрол, ажил, амьдралын замналаа төлөвлөх, хөгжүүлэх эх үүсвэр байна.
- Их өгөгдлийг хиймэл оюун ухаанд суурилан, төлөвлөлтөөс шийдвэр гаргах хүртэлх үйл явцад ёс зүйтэй ашиглана.

Нэгэн зүйл. Боловсролын санхүүжилт

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлнэ.
- Санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин, урамшууллын тогтолцоог бэхжүүлнэ.
- Сургалтын байгууллагын санхүүжилтийг захиран зарцуулахад талуудын оролцоог хангах бодлого, үйл ажиллагааг сайжруулна.

ДҮГНЭЛТ

Дэлхий дахины нийгэм, эдийн засгийн нөхцөл, уур амьсгал, эко системийн өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил, бүтээмэл оюун ба их өгөгдлөөс үүдэн ойрын ирээдүй тодорхойгүй, таамаглахад бэрхтэй, тогтворгүй, ээдрээтэй болж байна.

Олон улсын байгууллага, эрдэмтэд, судлаачид, нийгмийн олон салбарт бий болсон шинэ нөхцөл байдал, тулгамдаж буй сорилтыг даван туулахад боловсролын салбарын гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг боловсруулахад нийгмийн олон талын оролцоог хангахыг уриалах болов.

Дээр дурдсан нөхцөл байдал, олон улсын төлөв хандлагыг харгалзан Монголын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санааг сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйг дэмжих төв, аймаг, нийслэлийн боловсрол, шинжлэх ухааны газар, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод /эцэг, эхийн холбоо/, хүүхэд залуучуудын төлөөлөл, олон улсын байгууллагууд, Шинжлэх ухааны Академи, түүний харьяа хүрээлэн, төвийн судлаачид зэрэг 1464 төлөөллийг танхим, цахимаар оролцуулан цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчдоос ирүүлсэн санал, зөвлөмжөөс гарсан үр дүнг экспертийн ярилцлагаар сайжруулан баталгаажуулав.

Дэлхий дахины болон үндэсний түвшний сорилт, нийгмийн болон хувь хүний хэрэгцээ шаардлага, олон улсын болон үндэсний бодлогын баримт бичгүүд, цуврал хэлэлцүүлгийн үр дүнг эш үндэс болгон Монголын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санааны нэгэн хувилбарыг боловсролын динамик загварт суурилан дараах бүтцийн хүрээтэй байхаар тодорхойлов. Ингэхдээ:

Оршин тогтнохын үндэс нь Монголын боловсролын философи, Чиглэх алтан гадас нь Алсын хараа, Алсын хараа руу хөтлөх луужин нь Үнэт зүйл, Нийгэмд төлөвших хүн нь Монгол суралцагч, Монгол суралцагчийг дэмжих Тэргүүлэх чиглэлүүд, Олон нийтийн оролцоог эрхэмлэсэн Хамтын ажиллагаа, түншлэл, Хэрэгжилтийг найдвартай, тогтвортой байлгах Боловсролын цахим шилжилт ба их өгөгдөл, Үр дүнд суурилсан Боловсролын санжүүжилт хэмжээн тодорхойлж байна.

Ингэснээр Монгол улс дэлхийн боловсролын хөгжилд өөрийн өнгө аястай, монгол философид суурилсан боловсролын хөгжлийн туршлагаар хувь нэмрээ оруулах үйл ажиллагааны шанг татсан хэмээн үзэж байна. Мөн Монгол улсын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санааг хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийг “Нэгэн зүйл”-ээр тодорхойлсон нь цаашид боловсролын түвшин бүрийн боловсрол, сургалтын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэхэд хөтөч болох ач холбогдолтой юм.

Цаашид энэхүү үзэл санааны бүтцийн хүрээг шинээр баталсан Боловсролын ерөнхий хууль, боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулах, боловсролын салбарт хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөний үндэслэл болгох, ингэснээр боловсролын салбарын үйл ажиллагаа системийн хувьд шүтэлцээтэй, тогтвортой, үр дүнтэй хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ хэмээн үзэж байна. Түүнчлэн дээрх тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон аргагүй, үйл явц нь цаашид боловсролын төдийгүй бусад салбарт алсын хараа, бодлогын тэргүүлэх чиглэл, тулгамдаж буй сорилтыг даван туулах арга стратегийг нийгмийн олон талын зөвшилцөлд суурилж боловсруулах, тогтвортой хэрэгжүүлэх жишиг бэнчмарк болох боломжтой гэж үзэв.

ТАЛАРХАЛ

Тус судалгааны хэлэлцүүлэгт 1464 оролцогч, ярилцлагад боловсролын шинжлэх ухааны 3, боловсролын 21 доктор, БСҮХ-ийн эрдмийн зөвлөлийн гишүүд, уулзалт мэтгэлцээнд оролцсон Ерөнхийлөгчийн болон ерөнхий сайдын зөвлөхүүд, УИХ-ын боловсрол хариуцсан төлөөлөл, Боловсрол, шинжлэх ухааны яамны баг хамт олон, үндэсний чуулганд оролцож өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн, тунхаг бичигт нэгдсэн оролцогчид, энэ их үйл ажиллагааг зохион байгуулагчид, түүний дотор БСҮХ-ийн хамт олондоо гүн талархал илэрхийлье.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс: М.И.; **Арга зүй:** М.И., Х.О.; **Мэдээлэл цуглуулалт:** Х.О., С.С., У.Т., Х.Э., Ж.Д.; **Мэдээллийн зохион байгуулалт:** М.И., Х.О.; **Бичилт (эхний хувилбар):** М.И., Х.О.; **Бичилт (хянах, засварлах):** Х.О., С.С., У.Т.; **Хэлбэржүүлэлт:** М.И., С.С., Х.О., У.Т.; **Мэргэжлийн удирдлага:** У.Т., Х.Э., С.С., Х.О.; **Төслийн зохицуулалт:** Х.Э., У.Т., М.И., С.С., Ж.Д.

НОМ ЗҮЙ

- БСШУЯ. (2002). Бага дунд боловсролын киррикулим болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал. Боловсролын салбарын тогтоол, тушаалын эмхэтгэл, Боть. 10, х. 76-86.
- БСШУСЯ, БХ, ЮНЕСКО. (2019). Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. УБ.
- Бүжидмаа, Ц. (2001). Глобал иргэншил – Монгол улсын боловсролын философи үндэслэл.
- БШУЯ, БСҮХ. (2022). “Хувьсаж буй боловсрол” үндэсний хэлэлцүүлэг. УБ. Татаж авсан холбоос [2_5ce88a676c.pdf \(mnier.mn\)](#)
- БШУЯ. (2020). Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө. Татаж авсан холбоос <https://www.meds.gov.mn/боловсролын-салбарын-хөгжлийн-дунд-хугацааны-төлөвлөгөө>
- Бэгз, Н. (2017). *Монголын боловсрол судлалын шинэ парадигм*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бэгз, Н., (2008). *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд*. УБ. Соёмбо принтинг.
- Бэгз, Н., Бадарч Д. (2005). Боловсролын удирдлага зохион байгуулалтын шинэчлэл. *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд хурлын эмхэтгэл*. х. 5 – 15.
- Доёд, У., Нэргүй Н., Шагдар Л. (1993). Системийн хандлагын үндсэн ойлголт, зарчим. *Эрдэм ухаанд сургах үндэсний технологи*, 1, х. 16-20
- Итгэл, М., Отгонбаатар, Х., Туяа, У., Эрдэнэ, Л., & Пунцагсүрэн, Д. (2023). Боловсролыг системийн үзлээр хөгжүүлэх шийдлүүд. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл*, 28(1). <https://doi.org/10.56380/mjer.v28.1.2>
- Мөнхдалай, З. (1998). *Боловсролын менежмент*. УБ.
- Надмид, Ж. (1967). *Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн тойм*. УБ.
- Пүрэвдорж, Ч. (2002). Боловсролын дифференциал хөгжлийн зүй тогтол. *Монголын боловсрол судлаач эрдэмтдийн сонгомол өгүүллийн түүвэр*. х. 84 – 95.
- УИХ. (1992). Монгол улсын үндсэн хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- УИХ. (1995). Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай. Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=3782>
- УИХ. (2002). Боловсролын тухай хууль. Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail/9020>
- УИХ. (2008). Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль.
- УИХ. (2009). Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=101767>
- УИХ. (2015). Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail/10935>
- УИХ. (2020). “Алсын хараа -2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057>
- УИХ. (2023). Боловсролын ерөнхий хууль. Монгол Улсын хууль. Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>
- Шагдарсүрэн, Ц. (1981). *Монгол үсэг зүй*. УБ.

- Энхтүвшин, Б. (2014). *Монголын боловсрол, иргэний судлал*. УБ.
- Эрдэнэбаатар, Д., Аллард Ф., Батболд Н., Миллер В. Хүннүгийн булшнаас тамгатай шагай. *Түүхийн судлал*. 33. х.176 – 189.
- ЮНЕСКО, ШУА. (2016). Амьдралыг тэтгэгч тогтолцооны нэвтэрхий толь. Тогтвортой хөгжлийн мэдлэг. Боть 1.
- ЮНЕСКО. (2016). “Тогтвортой хөгжлийн зорилго 4 – Боловсрол 2030”-ийг дэлгэрүүлж ойлгох нь. Гарын авлага.
- Aris, N. F. M., Omar, S. S., & Hashim, F. (2021). VUCA: theories, concepts, and its remedy. Leading through the COVID-19 Crisis, 1. Татаж авсан холбоос http://eprints.uthm.edu.my/7637/1/C3866_2fe0262df8d6e398c916ca96bb761028.pdf#page=8
- Carleton, M., Cockayne W., Tahvanainen A. (2013). *Playbook for strategic foresight and innovation*. Stanford.
- Enkh-Amgalan, L. (2022, Sep. 19). Committing to Transformation [Video]. YouTube. <https://www.youtube.com/watch?v=ICBE0XKgAEA>
- OECD. (2019). Future of Education and Skills 2030. Conceptual learning framework. Skills for 2030. Татаж авсан холбоос <https://www.oecd.org/en/about/projects/future-of-education-and-skills-2030.html>
- OECD. (2021). Building the future of education. Татаж авсан холбоос <https://www.oecd.org/education/future-of-education-brochure.pdf>
- Ornshein, A.C., Levine D.U. (2008). *Foundations of Education*. Boston.
- WEF. (2020). The future of jobs report 2020. Татаж авсан холбоос <https://www.weforum.org/publications/the-future-of-jobs-report-2020/in-full/>
- WEF. (2023). The future of jobs report 2020. Татаж авсан холбоос <https://www.weforum.org/publications/the-future-of-jobs-report-2020/in-full/>
- UNESCO. (2021). Reimagining our futures together: a new social contract for education. Paris, 186 pages, ISBN 978-92-3-100478-0. Татаж авсан холбоос [Reimagining our futures together: a new social contract for education;executive summary - UNESCO Digital Library](https://www.unesco.org/digital-library/reimagining-our-futures-together-a-new-social-contract-for-education-executive-summary)

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Миеэжавын Итгэл

 <https://orcid.org/0000-0001-9854-5604>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 10,

Багшийн хөгжлийн ордон 405 тоот

Улс: Монгол

e-mail: itgel@mier.mn

Овог, нэр: Хажидмаагийн Отгонбаатар

 <https://orcid.org/0000-0001-9633-626X>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 10,

Багшийн хөгжлийн ордон 304 тоот

Улс: Монгол

e-mail: otgonbaatar@mier.mn

Овог, нэр: Сэдийн Санжаабадам

 <https://orcid.org/0000-0002-9201-0358>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 10,

Багшийн хөгжлийн ордон 302 тоот

Улс: Монгол

e-mail: sanjaabadam@mier.mn

Овог, нэр: Ухнаагийн Туяа

 <https://orcid.org/0000-0001-7761-0980>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 10,

МУБИС-ийн IX байр, 302 тоот

Улс: Монгол

e-mail: tuya@mier.mn

Овог, нэр: Халгарын Энхжаргал

 <https://orcid.org/0000-0002-5076-6480>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 10,

МУБИС-ийн IX байр, 305 тоот

Улс: Монгол

e-mail: enkhjargal@mier.mn

Овог, нэр: Жаргалсайханы Дэнсмаа

 <https://orcid.org/0000-0002-2708-8415>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 10,

МУБИС-ийн IX байр, 303 тоот

Улс: Монгол

e-mail: densmaa@mier.mn